

Living the LOTUS

Buddhism in Everyday Life



VOL. 166

Үүсгэн байгуулагчийн сургаал

Хүлээцтэй байх

Хүнийг өсгөж хүмүүжүүлэхэд хамгийн чухал нь “Хүлээцтэй байх” чанар болов уу. Хүн өөрийн сул тал болон муу зуршлаа засаж залруулахад тийм ч амар биш. Ажил хэрэг дээр дээд тушаалын ажилтан өөрөөсөө доод тушаалын ажилтандаа янз бүрийн анхааруулга өгч “ийм алдаа дахиж гаргав аа” гэж хичнээн хэллээ ч дорхноо засрах нь юу л бол.

Ээжүүд хүүхдэдээ “Ойлгосон гээ биз дээ”, “Дахиж тэгэхгүй гэж амлаа биз дээ”, “Хэд хэлүүлж байж чи ойлгох юм бэ” гээд л загнаж харагддаг. Толгойдоо ойлгосноо бодитоор хэрэгжүүлж чадах хоёрын хооронд тэнгэр газар шиг л ялгаа бий.

Жишээлбэл, баруун талын ширээн дээрхийг

зүүн талын ширээ рүү аваад тавих хэмжээний амархан мэт харагдах зүйл байлаа ч урт удаан хугацааны туршид тухайн хүний хийж ирсэн арга барил болон зуршлыг өөрчлөх амаргүй. Хэд дахин алдаж байж, арай хийн биед дадаж, өөрчлөгддөг. Тэр үед нь тусалж дэмжиж, хүлээцтэй хандаж сурах уужуу, дулаан сэтгэл үгүй бол хүн өсөж хөгжихгүй.

Та өөрөө одоо бүгдийг ойлгосон мэт царай гаргаж байж болох ч, хичнээн хүний тус дэм, уужуу сэтгэлийн хүчинд өдий хүрсэнээ эргэн нэг санаарай.

Үүсгэн байгуулагчийн сургаал 9, Х.218-219

Living the Lotus Vol. 166 (2019,07)

Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс

Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan

TEL: +81-3-5341-1124

FAX: +81-3-5341-1224

Email: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Ахлах редактор: Сайтоо Коочироо

Орчуулсан: Ж.Сэлэнгэ

Эхийг хянасан: Монголын РКК

Рисшо Косей кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо болон түүний шавь Хамтран үндэслэгч Наганүма Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Турван Эрдэнийн Цагаан Лянхуа Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулья гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Гишүүд бид бурхан багшийн шавь болохынхоо хувьд тус байгууллагын Ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн, энх тайвны олон янзын үйл ажиллагаа явуулж байна.

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнэтэй амьдралыг тууцгаая гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.

“Юунд ч үл баригдах эрх чөлөөт” амьдрал

Рисшо Косей Кай, Ерөнхийлөгч
Нивано Ничикоо



Жинхэнэ “Эрх чөлөө” ба ”юунд ч үл баригдах амьдрал”

Бид бүхэн өөрийн санасан зоргоор үйл хөдлөл хийхийг “Эрх чөлөө” гэж нэрлэн, түүнийгээ “юунд ч үл баригдах” амьдрал хэмээн боддог. Тэгээд олонх нь “эрх чөлөөтэй дураараа амьдарч чаддаг бол хичнээн сайхан бэ” гэж боддог. Нөгөө өнцгөөс нь харах юм бол бид ер нь хичнээн эрх чөлөөгүй, сэтгэл ханамжгүй байдаг юм бэ.

Гэвч энэ нь мэдээжийн зүйл юм. Өөрийнхөө санаснаар байж чадахыг “Эрх чөлөө” хэмээн бодож, санаснаар болохгүй бодит үнэнтэй нүүр тулгарах бүртээ дутагдан гачигдаж, сэтгэлээр унаж, бухимдан зовж, эрх чөлөөгүй байна хэмээх бодлоо улам дэвэргэж байдаг учраас юм. Энэ нөхцөл байдлыг “Эрх чөлөө”-г хүсэхдээ эсрэгээрээ өөрөө өөртөө эрх чөлөөт бус байдлыг урин дуудах гэж хэлж болно. Угтаа эрх чөлөөгүй мэт санагдах тэр л үед жинхэнэ “Эрх чөлөө”, “юунд ч үл баригдах” амьдралыг өөртөө хэвшүүлэх сайхан боломж ч байж мэдэх юм.

Бурханы сургаалд хүсэл шуналдаа автах, хэт өөрийнхөө үзэл баримтлалдаа автах сэтгэл ор мөргүй алга болохыг “цэнгэл баясал” гээд, тийн юунд ч үл баригдах сэтгэлийг “Эрх чөлөө” гэсэн байдаг. Дотор бачуурч, хорсож үзэн ядах зүйл ч үгүй сэтгэл санаа уужуу тайван түвшин юм.

Мөн “юунд ч үл баригдах” гэдэгт Арьяавал Бодисадваг “чөлөөтэй хардаг билигт Бодисадва” хэмээн дууддаг шиг зовсон нэгний дуу хоолойг сонсож, ямар л бол ямар аргаар аврах, хүч чадал бий гэсэн утгыг давхар агуулж байдаг. Өөрөөр хэлбэл бусдыг энэрч хайрлах, хамтдаа өсөж дэвжихийг тэмүүлэх амьдралын замналд жинхэнэ “Эрх чөлөө”, ”юунд ч үл баригдах” амьдрал бий гэсэн үг юм.





“Гурван ертөнц бол биднийх”

Цагаан Лянхуа Сударын “Үлгэрлэн зүйрлэлийг үгүүлэхүй” бүлэгт “Би бол энэ ард түмний эцэг нь. Зовлон бэрхшээлийг даван Хэмжээ хязгааргүй Бурханы билиг оюуны жаргалыг хүртээгээд Тийн үйлдээд тоглож наадуулвал зохимуй” хэмээх нэг мөрт бий.

Эрх чөлөөгүй мэтээр бодож, зовлон бэрхшээлээс тойрон зугтахыг хүсэх бидэнд Бурхан багш “билиг оюуны цэнгэл”-г хайрлаж, жинхэнэ эрх чөлөөт, юунд ч үл баригдах амьдралыг бэлэглэе хэмээж байна. Тэгвэл тэрхүү “билиг оюуны цэнгэл” гэж юуг хэлэх вэ?

Жишээлбэл таны өмнө 2 ширхэг боорцог байна гэж бодъё. Энэ боорцог хоёулаа таных. Гэтэл дэргэд чинь тантай ижил гэдэс нь өлссөн дөрвөн ч хүн байна.

“Олон зовлонгийн шалтгаан бол Хүсэл шунал болой.” хэмээн сударт гардаг шиг таны бусдаас авсныгаа ганцаараа идэхийг хүсэх сэтгэл (шунал) ч, авч чадаагүй хүмүүсийн атаархаж, үзэн ядах сэтгэл (уур хилэн) ч зовлонгийн нэгэн шалтгаан. Тэгвэл хүрэлцэхгүй байгаагаа Бурханаас гуйгаад авчихвал болоо биш үү, түүнийг “билиг оюуны цэнгэл” гэх биш үү гэж бодох хүн байж магадгүй. “Билиг оюуны цэнгэл” гэж үүнийг хэлэхгүй. Тэрхүү дутагдал гачигдлаас үүдэн учрах зовлон бэрхшээлийг өөрийгөө болон өрөөл бусдыг хөгжүүлэх шат, баяр хөөр хэмээн хүлээж авдаг болох нь “билиг оюуны цэнгэл” гэсэн үг.

Эрх чөлөө гэдэг үгээр илэрхийлэх юм бол бидэнд хэцүү бэрхийг “Өөдрөгөөр хүлээн авах эрх чөлөө”-г Бурхан багш хайрласан гэж хэлж болно. Зовж зүдэрсэн үед нөхцөл байдлыг байгаа чигээр нь хүлээн авч, нүдний өмнөх бяцхан аз жаргалыг олж хараад, баяр баяслаа бусадтайгаа хуваалцсанаар зовлон зүдгүүрийг баяр хөөрөөр өөрчлөх болно. Үүнийг л жинхэнэ “Юунд ч үл баригдах, эрх чөлөөт” амьдрал гэх болов уу гэж бодож байна.

Мөн “Үлгэрлэн зүйрлэсэн бүлэг”-т “Би бээр өдгөө гурван орон эзэгнэхүй еэ” (Энэ хорвоо ертөнц, сансар огторгуй бол минийх) гэсэн байдаг. Бид өөрсдийгөө дутуу үнэлээд “огт тэгэж төсөөлж чадахгүй нь” гэж боддог ба бид бүгд тус бүртээ давтагдашгүй эрхэм нандин амь насыг хүртэн, их байгалийн нэгэн хэсэг болон бүгдтэй эв найрамдалтай амьдарч буй билээ. Эндээс харахад сансар огторгуй бүхэлдээ надтай нэгэн бүхэл юм бол бүгд минийх гэсэн үг болно. Дээрх мөрт нь “Үүнийг ойлговол үргэлж билиг оюун хийгээд энэрэл нигүүлслээр цалгисан үйлдлийг хийж чадна” хэмээн биднийг урамшуулан дэмжиж, тийм байгаасай гэж хүсэх Бурхан багшийн дохио юм.

Үүнээс улбаалаад та бүгдээс нэгэн зүйлийг асууя. Та бүхэн байсан бол дээрх 2 боорцгийг яах байсан бэ?

«Косей» сэтгүүлийн 2019 оны 7 сарын дугаараас



Лянхуан Гурамсан Сударын бүлэг тус бүрийн тайлбар

Суралцагч, үл суралцагч нарт эш үзүүлснийг өгүүлэх 9 дүгээр бүлэг



Таван зуун шавь нар эш авч, Бурхан болох нь батлагдсан байтал арван их шавь дотор багтах Рахула (Шагжамүни Бурханы ганц хүү), Ананда (Шагжамүни Бурханы үеэл дүү) нар “Яагаад биднийг Бурхан болохыг батлахгүй байна вэ” хэмээн гунигтай байв. Бодож бодож Бурхан багшаас Бурхан болохыг нь баталж өгөхийг гуйтал Бурхан багш дор нь ёсоор болгов. Мөн түүнтэй зэрэг олон суралцагч (Хараахан бүрэн дүүрэн суралцаагүй байгаа бясалгагч) хийгээд үл суралцагч (Хэдийн сурах ёстойгоо суралцаад дуусгачихсан бясалгагч) шавь нарт ч Бурхан болохыг нь баталж, эш олгов.

Энэ бүлэг үйл явдлын хувьд зөвхөн энэ тухай л өгүүлсэн, цомхон бүлэг шиг харагдах боловч бид эндээс хоёр чухал зүйлийг ойлгон сурч болно.

Бурханлаг чанарыг биеэрээ мэдэрч байж гэмээнэ Бурхан болж чадна

Нэгдүгээрт юуг ойлгох ёстой вэ гэхээр суралцах зүйл нь хараахан дуусаагүй, өөрөөр хэлбэл даган суралцагч бясалгагчийн түвшний хүмүүст Бурхан болох баталгаа өгч, эш үзүүлсэн гэдэг хэсэг. Өнгөц харахад гайхмаар юм шиг ч, сайтар бодоод үзвэл гайхах зүйл үгүй. Бүх хүн адилхан бурханлаг чанартай бөгөөд түүнийгээ ил тодорхой болгож, бүрэн гүйцэт биеэрээ мэдэрч байж л Бурхан болон гэгээрч чадах учиртай.

Ойр дотны хүнээ сургаалын зам мөрт оруулахад бэрх

Хоёрдугаарт арван их шавь нарт хүртэл багтдаг Рахула болон Ананда нарыг яагаад бусдаас нь хамаагүй хоцроож, арай гэж

ширваган шавь нартай цуг Бурхан болохыг нь батлав аа... гэсэн хэсэг.

Шагжамүни Бурханы хувьд эл учрыг таамаглаж нэг үзвээс Рахула бол Шагжамүни Бурханы жинхэнэ хүүхэд, Ананда ч өөрийнх нь үеэл бөгөөд 20 хэдэн жил дэргэдээс нь холдоогүй туслагч, хоёулаа л Шагжамүни Бурханы хамгийн ойр дотно хүмүүс учраас эсрэгээрээ бясалгахад нь саадтай тал байгааг бодолцож үзээд, түүнийгээ бүгдэд үзүүлэхийн тулд зориуд оройтуулсан байх хэмээн бодогдно.

Анандын хувьд үргэлж дэргэд нь байж, хоол ундыг нь ч хийж, усанд орох үед нь нурууг нь угааж өгдөг тийм л ойрын байр сууринд байж, Шагжамүни бурханы жирийн хүн гэсэн талыг түлхүү хардаг болохоор яалтчгүй бусад шавь нар лугаа цайлган сэтгэлээр Шагжамүни бурхан хийгээд, түүний сургаал номонд сүсэглэх нь амаргүй байх нь гарцаагүй.

Рахула ч гэсэн аав нь хичнээн эрхэм чухал хүн байлаа ч гадны хүн бурханыг сэтгэл зүрхнээсээ тахин шүтэхтэй ижил сэтгэлээр төрсөн эцэгтээ хандана гэдэг хэцүү бөгөөд түүний дотор эцэгтээ эрхлэн туньсан сэтгэл огтоос байгаагүй гэж хэлэх аргагүй.



Үүнээс үүдээд бид бүхэн ойр дотны хүмүүс болох эхнэр нөхөр, эсвэл хүүхэд эцэг эх зэрэг хүмүүсээ сургаалын замд оруулах нь хамгаас хэцүү зүйл болж байгаа юм. Үүний тулд зөвхөн амаараа хэлж яриад нэмэргүй. Өдөр тутмын амьдралдаа бодитоор хийж хэрэгжүүлж, үлгэрлэж үзүүлэхээс нааш бүтэхгүй.

Тухайн хэрэгжүүлэлт, үйл хэрэг нь хааяа л нэг хэрэгжээд, ихэнхдээ өөрийн дураараа, зөв шударга биш байвал сайн үлгэр жишээ болж чадахгүйгээс гадна, гэр бүлийнхэн болон ажлын газрын хүнээ эгнээндээ элсүүлж чадахгүй л болов уу.

Ананда, Рахула нар бусад нэр нөлөө бүхий их шавь нараас хожуу гэгээрсэн гэж дурдагдсан ч номын чуулганыг өөрсдийн хүслээр орхин одсон “500 шавь” нараас хоцорсон гэсэн үг биш юм. Үүний цаана дээр өгүүлсэн лүгээ Шагжамүни Бурханы гүн гүнзгий нигүүлсэл байсан гэж таамаглахаас өөр аргагүй. Ингэж хүлээж авах нь хожмын үеийн Бурханы шавь нарын хувьд зөв үйлдэл хэмээн итгэнэ.

Язгуурын хүсэл

Энэ бүлэгт өөр нэгэн чухал зүйлийг заадаг. Тэр бол шинээр боди сэтгэлийг үүсгэсэн 8 мянган Бодисадва нарт хандан Шагжамүни Бурхан Анандын Бурхан болохыг батлахтай зэрэгцэн “тэрхүү язгуурын хүсэл нь энэ мэт болой” гэж өгүүлдэг.

“Язгуурын хүсэл” гэдэг нь олон Бурхан, Бодисадва нарын өмнөх төрөлдөө эх болсон зургаан зүйл хамаг амьтныг аврана гэж өргөсөн тангарагийг хэлнэ. Жишээлбэл Бурхан Будда 500 их тангараг, Авид Бурханы 48 тангараг, Оточ Манал Бурханы 12 тангараг гэж байдаг.

Шинээр боди сэтгэлийг үүсгэсэн Бодисадва нар дахин төрөхдөө өмнөх төрөлдөө өргөсөн тангарагаа мартчихсан байсан ч, өмнөх насандаа бүх хүнийг Бурханы мөрд орох хүслийг нь гүйцэлдүүлэхийг зорилгоо болгосон байсан. Тийнхүү одоо Цагаан Лянхуа Сударын сургаалыг сонсоод, язгуурын хүслээ эргэн санасан ажээ. Тиймээс энэ бүлэгт Бурханы гэгээрлийг олж чаднаа гэсэн баталгааг авч байгаа юм.

Энэ бол бидэнд ч хамаарах зүйл. Өмнөх төрөлдөө тавьсан тангарагаа эргэн сэргээж, бат зогссон хүн л жинхэнэ Бодисадва бөгөөд Номын багш мөн.



Нивано Никкёо “Лянхуан Гурамсан Сударын бүлэг тус бүрийн тайлбар /шинэ хэвлэл/”, Косей хэвлэлийн компани, 2016, X. 94-98

Living the
 **LOTUS**

Хамтдаа аврагдах ертөнцийг зорьж

7 сар нь АНУ-д сургаал түгсний 60 жилийн ойг тэмдэглэх сар билээ. Олон улсад сургаал түгсэн үйл явдлын түүхэнд шинэ хуудсыг нээх эхлэл ч гэж хэлж болно. Дэлхийн санга буюу номын андууд та нартайгаа хамтдаа хойшид ч сургаад түгээх үйлсийн төлөө эрч хүч дүүрэн зүтгэе хэмээн бодож байна.


Энэ сарын сэтгүүлийн гишүүний илтгэлийн хэсэгт “Накагава гишүүн өөрийн эцэгтэйгээ хэрхэн харилцахаа мэдэхгүй шаналж байсан тухайгаа дурджээ. Мөн өөрийн харах өнцөгөө өөрчилж, бүх зүйл шаардлагатай болоод үүссэн хэмээн хүлээн аваад аавынхаа бурханлаг чанарт итгэх сэтгэлтэй болсноороо эцгийнхээ шаналалыг ойлгож, талархсан сэтгэлээр дахин уулзахсан гэж боддог болсон. Тэгтэл үнэхээр хүслээр нь болж аавтайгаа дахин уулзалдаж чадсан ба аавдаа одоо бол маш их хайртай” гэж бичсэнийг нь уншаад үнэхээр сэтгэл дулаацам сайхан түүх шиг санагдлаа.

Нивано ерөнхийлөгч “юунд ч үл баригдах эрх чөлөөтэй амьдрах” гэсэн сургаалдаа “зовлон бэрхшээлийг баяр хөөрөөр өөрчлөхийг юунд ч үл баригдах эрх чөлөөтэй амьдрал гэх буй за” хэмээн айлджээ. Өөрийн амь насны үнэ цэнийг ухаарч, бусдын хамтаар аврагдах хорвоо ертөнцийг цогцлоохыг зорьж, бусдын төлөө гэсэн энэрэнгүй сэтгэлээр хойшид үйл хэргээ үргэлжлүүлцгээе.

РКК, Олон улсын хэлтсийн дарга
Саитоо Коичи



Rissho Kosei-kai: A Global Buddhist Movement



Rissho Kosei-kai International

Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
 Tel: 81-3-5341-1124 Fax: 81-3-5341-1224
 e-mail: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First Street, Suite #1, Los Angeles, CA 90033, U.S.A.
 Tel: 1-323-262-4430 Fax: 1-323-262-4437
 e-mail: info@rkina.org <http://www.rkina.org>

Branch under RKINA

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003 U.S.A.
 Tel: 1-253-945-0024 Fax: 1-253-945-0261
 e-mail: rkseattlewashington@gmail.com
<http://buddhistlearningcenter.org/>

Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio

6083 Babcock Road, San Antonio, TX 78240, U.S.A.
 P.O. Box 692148, San Antonio, TX 78269, U.S.A.
 Tel: 1-210-561-7991 Fax: 1-210-696-7745
 e-mail: dharmasanantonio@gmail.com
<http://www.rkina.org/sanantonio.html>

Rissho Kosei-kai of Tampa Bay

2470 Nursery Road, Clearwater, FL 33764, U.S.A.
 Tel: (727) 560-2927 e-mail: rktampabay@yahoo.com
<http://www.buddhismtampabay.org/>

Rissho Kosei-kai of Vancouver

Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, U.S.A.
 Tel: 1-808-455-3212 Fax: 1-808-455-4633
 e-mail: info@rkhawaii.org <http://www.rkhawaii.org>

Rissho Kosei-kai Maui Dharma Center

1817 Nani Street, Wailuku, HI 96793, U.S.A.
 Tel: 1-808-242-6175 Fax: 1-808-244-4625

Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740 U.S.A.
 Tel: 1-808-325-0015 Fax: 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, U.S.A.
 Tel: 1-323-269-4741 Fax: 1-323-269-4567
 e-mail: rk-la@sbcglobal.net <http://www.rkina.org/losangeles.html>

Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona

Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado
 Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego
 Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas
 Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas

Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, U.S.A.
 Tel: 1-650-359-6951 Fax: 1-650-359-6437
 e-mail: info@rksf.org <http://www.rksf.org>

Rissho Kosei-kai of Sacramento

Rissho Kosei-kai of San Jose

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016 U.S.A.
 Tel: 1-212-867-5677 Fax: 1-212-697-6499
 e-mail: rkny39@gmail.com <http://rk-ny.org/>

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056 U.S.A.
 Tel: 1-773-842-5654 e-mail: murakami4838@aol.com
<http://rkchi.org/>

Rissho Kosei-kai of Fort Myers

<http://www.rkftmyersbuddhism.org/>

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th Street, Oklahoma City, OK 73112 U.S.A.
 Tel: 1-405-943-5030 Fax: 1-405-943-5303
 e-mail: rkokdc@gmail.com <http://www.rkok-dharmacenter.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Denver

1255 Galapago Street, #809 Denver, CO 80204 U.S.A.
 Tel: 1-303-446-0792

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

425 Patterson Road, Dayton, OH 45419 U.S.A.
<http://www.rkina-dayton.com/>

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP,
 CEP 04116-060 Brasil
 Tel: 55-11-5549-4446 / 55-11-5573-8377 Fax: 55-11-5549-4304
 e-mail: rissho@terra.com.br <http://www.rkk.org.br>

Rissho Kosei-kai de Mogi das Cruzes

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP,
 CEP 08730-000 Brasil
 Tel: 55-11-5549-4446 / 55-11-5573-8377

Rissho Kosei-kai of Taipei

4F, No. 10 Hengyang Road, Zhongjheng District,
Taipei City 100, Taiwan

Tel: 886-2-2381-1632 Fax: 886-2-2331-3433
<http://kosei-kai.blogspot.com/>

Rissho Kosei-kai of Tainan

No. 45, Chongming 23rd Street, East District,
Tainan City 701, Taiwan

Tel: 886-6-289-1478 Fax: 886-6-289-1488

Korean Rissho Kosei-kai

6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420,
Republic of Korea

Tel: 82-2-796-5571 Fax: 82-2-796-1696
e-mail: krkk1125@hotmail.com

Korean Rissho Kosei-kai of Busan

3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea
Tel: 82-51-643-5571 Fax: 82-51-643-5572

International Buddhist Congregation (IBC)

Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan

Tel: 81-3-5341-1230 Fax: 81-3-5341-1224

e-mail: ibcrk@kosei-kai.or.jp <http://www.ibrk-rk.org/>

Branches under the Headquarters**Rissho Kosei-kai of Hong Kong**

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road,
North Point, Hong Kong, Republic of China

Rissho Kosei-kai of Ulaanbaatar

15F Express tower, Peace avenue, khoroo-1, Chingeltei district,
Ulaanbaatar 15160, Mongolia

Tel: 976-70006960 *e-mail:* rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Sakhalin

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk
693005, Russian Federation

Tel & Fax: 7-4242-77-05-14

Rissho Kosei-kai Friends in Shanghai**Rissho Kosei-kai of South Asia Division**

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand

Tel: 66-2-716-8141 Fax: 66-2-716-8218

Rissho Kosei-kai International of South Asia (RKISA)

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand

Tel: 66-2-716-8141 Fax: 66-2-716-8218

e-mail: thairissho@csloxinfo.com

Branches under the South Asia Division**Rissho Kosei-kai of Delhi**

77 Basement D.D.A. Site No. 1, New Rajinder Nagar,
New Delhi 110060, India

Rissho Kosei-kai of Kolkata

E-243 B. P. Township, P. O. Panchasayar, Kolkata 700094,
West Bengal, India

Rissho Kosei-kai of Kolkata North

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059,
West Bengal, India

Rissho Kosei-kai of Bodhgaya

Ambedkar Nagar, West Police Line Road
Rumpur, Gaya-823001, Bihar, India

Rissho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsilhel, Sancepa-1, Lalitpur, Kathmandu,
Nepal

Rissho Kosei-kai of Phnom Penh

#201E2, St 128, Sangkat Mittapheap, Khan 7 Makara,
Phnom Penh, Cambodia

Rissho Kosei-kai of Patna**Rissho Kosei-kai of Singapore****Thai Rissho Friendship Foundation**

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand

Tel: 66-2-716-8141 Fax: 66-2-716-8218

e-mail: info.thairissho@gmail.com

Rissho Kosei-kai of Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh

Tel & Fax: 880-31-626575

Rissho Kosei-kai of Dhaka

House#408/8, Road#7(West), D.O.H.S Baridhara,
Dhaka Cant.-1206, Bangladesh

Tel & Fax: 880-2-8413855

Rissho Kosei-kai of Mayani

Mayani(Barua Para), Post Office: Abutorab, Police Station:
Mirshari, District: Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Patiya

Patiya, sadar, Patiya, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Domdama

Domdama, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Cox's Bazar

Ume Burmese Market, Main Road Teck Para, Cox'sbazar,
Bangladesh

Rissho Kosei-kai of Satbaria

Satbaria, Hajirpara, Chandanish, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Laksham

Dupchar (West Para), Bhora Jatgat pur, Laksham, Comilla,
Bangladesh

Rissho Kosei-kai of Raozan

West Raozan, Ramjan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Chendirpuni

Chendirpuni, Adhunagor, Lohagara, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Ramu**Rissho Kosei Dhamma Foundation, Sri Lanka**

No. 628-A, Station Road, Hunupitiya, Wattala, Sri Lanka

Tel: 94-11-2982406 Fax: 94-11-2982405

Rissho Kosei-kai of Habarana

151, Damulla Road, Habarana, Sri Lanka

Rissho Kosei-kai of Polonnaruwa**Branches under the Headquarters****Rissho Kosei-kai di Roma**

Via Torino, 29-00184 Roma, Italia

Tel & Fax: 39-06-48913949 *e-mail:* roma@rk-euro.org

Rissho Kosei-kai of the UK**Rissho Kosei-kai of Venezia****Rissho Kosei-kai of Paris**